



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/231

Мандалговь

“Тааны амт” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хийгдэх “Луус сумын Засаг даргын тамгын газрын дотор засвар” ажилд ирүүлсэн үнийн саналаар “Тааны амт” ХХК-тай 9,943,982 (есөн сая есөн зуун дөчин гурван мянга есөн зуун наян хоёр) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан төсвийн дагуу “Луус сумын Засаг даргын тамгын газрын дотор засвар ажил”-ыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тааны амт” ХХК-ний захирал (Ю.Отгондэлгэр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Луус сумын Засаг дарга (Б.Өлзийхишиг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРСАЙХАН



486211127